



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/27/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimeg.ts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalai.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Булганчимэг Утас: 261628 Цахим хаяг: bulganchimeg.e@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн Ерөнхий захирал: Ц.Жигдэн Утас: 70005401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД
БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ
САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Т.ОЧИРХҮҮ ТАНАА

2024.03.29 № 07/892

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн гүйцэтгэгч барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд дуусгаагүй, гүйцэтгэлийг хангаагүй, зарим барилгын ажил хийгдээгүй, зогсонги байдалтай, төслийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй зэрэг 2,605.927.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 287,437.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн Газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд байгуулсан 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн МОН-3594 дугаартай зээлийн гэрээний дагуу 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр хаагдахаар дахин сунгасан байна.

Аудитын гол асуудал

Төслийн нийт санхүүжилт болох 50.0 сая ам.доллороос 34.6 сая ам.долларыг бодитоор зарцуулсан нь нийт санхүүжилтийн 69.2 хувийг, төслийн хэрэгжилтийн хугацаанд нийт 38.4 сая ам.долларын гэрээ байгуулсан нь нийт санхүүжилтийн 76.7 хувийг тус тус эзэлж байна. Мөн төслийн магадалшгүй ажлын зардлын санхүүжилтээс 5.1 сая ам.долларыг зарцуулах хүсэлтийг шийдвэрлэдэг байгууллагуудад Төслийн удирдах хорооноос уламжилсан байна.

Төслийн хүрээнд 7 сургууль, 14 цэцэрлэг, нийт 21 барилга угсралтын ажил хийгдэхээр гэрээлснээс 4 сургууль, 10 цэцэрлэг ашиглалтад орсон ба тайлангийн хугацаанд нийт 12 барилгын ажил гүйцэтгэгчийн материалын үнийн өсөлтийн хүсэлтийг шийдвэрлэн, гэрээний нийт дүнг 9,668,207.9 мянган төгрөгөөр нэмж баталгаажуулсан.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслөөс 5 бүрэлдэхүүний нийт 96 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 79.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	51,094,733,001.55	82,583,062,969.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,949,943,396.73	2,045,305,885.99
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	1,949,943,396.73	2,045,305,885.99
31210	Төгрөг	1,304,637,371.86	1,730,614,991.92
31211	Төрийн сангийн харилцах	1,304,637,371.86	1,730,614,991.92
31220	Гадаад валют	645,306,024.87	314,690,894.07
31221	Төрийн сангийн харилцах	645,306,024.87	314,690,894.07
34	УРЬДЧИЛГАА	-	131,025,338.54
34600	Урьдчилж гарсан зардал	-	131,025,338.54
35	БАРАА МАТЕРИАЛ	8,859,514.27	8,046,400.00
35400	Хангамжийн материал	8,859,514.27	8,046,400.00
35410	Бичиг хэргийн материал	374,000.00	374,000.00
35420	Аж ахуйн материал	4,105,805.00	3,505,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,379,400.00	4,167,000.00
35440	Түлш, шатах тослох материал	309.27	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	49,135,930,090.55	80,398,685,344.90
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	49,135,930,090.55	80,398,685,344.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	182,207,456.27	33,785,765.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	182,207,456.27	33,785,765.56
39200	Биет хөрөнгө	180,398,074.55	33,626,383.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	189,000,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(72,145,161.29)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	115,401,980.00	121,300,908.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(64,510,678.33)	(101,317,688.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,797,700.00	23,868,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,145,765.83)	(10,225,535.83)
39300	Биет бус хөрөнгө	8,250,000.00	159,381.72
39301	Программ хангамж	8,250,000.00	8,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,440,618.28)	(8,090,618.28)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	51,276,940,457.82	82,616,848,734.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,093,844,508.68	8,841,443,144.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,093,844,508.68	8,841,443,144.92
41300	Өглөг	2,093,844,508.68	8,841,443,144.92
41360	Бусад өглөг	2,093,844,508.68	8,841,443,144.92
41361	Байгууллагад төлөх өглөг	2,093,844,508.68	8,841,443,144.92
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	49,183,095,949.14	73,775,405,590.07
51	Засгийн газрын хувь оролцоо	49,183,095,949.14	73,775,405,590.07
51200	Хуримтлагдсан үр дүн	49,183,095,949.14	73,775,405,590.07
51210	Өмнөх үеийн үр дүн	18,939,684,638.30	49,183,095,949.14
51220	Тайлант үеийн үр дүн	30,243,411,310.84	24,592,309,640.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	51,276,940,457.82	82,616,848,734.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	33,862,994,182.84	29,022,108,142.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,862,994,182.84	29,022,108,142.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,862,994,182.84	29,022,108,142.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,853,276,206.84	29,005,738,806.39
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	33,138,000,673.74	28,829,976,721.29
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	715,275,533.10	175,762,085.10
120009	Бусад орлого	9,717,976.00	16,369,335.61
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,868,969,222.42	4,320,028,298.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,868,969,222.42	4,320,028,298.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,868,969,222.42	4,320,028,298.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,253,818.18	487,321,647.05
210101	Үндсэн цалин	506,253,818.18	487,321,647.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлсөн шимтгэл	63,281,727.27	60,915,205.88
210201	Тэтгэврийн даатгал, болон бусад төрөл	63,281,727.27	60,915,205.88
2103	Байрны ашиглалтын тогтмол зардал	72,975,195.00	85,874,630.00
210304	Байрны түрээс	72,975,195.00	85,874,630.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,240,952.94	13,905,493.79
210401	Бичиг хэрэг	6,262,630.00	6,043,693.00
210402	Тээвэр, шатахуун	2,125,072.34	620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,853,250.60	7,241,800.79
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,280,630.00	1,149,000.00
210604	Урсгал зардал	4,280,630.00	1,149,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,029,844.36	43,088,709.27
210702	Дотоод албан томилолт	13,029,844.36	41,998,109.27
210703	Гадаад албан томилолт	-	1,090,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,342,741,593.67	792,612,407.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,311,407,216.67	753,240,184.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	27,797,000.00	33,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	174,048.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,209,000.00	6,198,175.00
210808	Банкны үйлчилгээний хураамж	154,329.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	849,165,461.00	2,835,161,205.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,050,000.00	880,322,359.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	798,117,526.00	1,904,852,066.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,997,935.00	49,986,780.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	29,994,024,960.42	24,702,079,843.71
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	249,386,350.42	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	249,386,350.42	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	109,770,202.78
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал хассаны гарз	-	109,077,643.71
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	692,559.07
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	30,243,411,310.84	24,592,309,640.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,211,919,420.85	7,757,137,684.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,211,919,420.85	7,757,137,684.57
120	Нийтлэг татварын бус орлого	6,211,919,420.85	7,757,137,684.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,211,169,420.85	7,740,768,348.96
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,211,169,420.85	7,740,768,348.96
120009	Бусад орлого	750,000.00	16,369,335.61
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,887,793,672.37	2,781,555,026.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,887,793,672.37	2,781,555,026.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,887,793,672.37	2,781,555,026.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,164,000.22	487,555,147.05
210101	Үндсэн цалин	506,164,000.22	487,555,147.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлсөн шимтгэл	63,281,727.27	60,915,205.88
210201	Тэтгэврийн даатгал	43,031,574.55	41,422,340.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,062,538.18	4,873,216.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,050,030.55	3,898,573.18
210204	Ажилгүйдлийн даатгал	1,012,507.64	974,643.29
210205	Эрүүл мэндийн даатгал	10,125,076.36	9,746,432.94
2103	Байрны ашиглалтын тогтмол зардал	73,826,238.00	85,874,630.00
210304	Байрны түрээс	73,826,238.00	85,874,630.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,389,837.60	15,143,293.79
210401	Бичиг хэрэг	6,363,630.00	6,394,693.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,826,207.60	6,866,800.79
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн зүйлс	1,600,000.00	1,881,800.00
2105	Нормативд зардал	-	4,477,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	4,477,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,800,600.00	2,873,400.00
210601	Багаж, техник хэрэгсэл	-	1,273,000.00
210604	Урсгал зардал	4,800,600.00	1,600,400.00
2107	Томилолт, зочны зардал	12,405,100.00	42,547,800.00
210702	Дотоод албан томилолт	12,405,100.00	42,547,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,206,680,369.27	2,066,630,169.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,206,506,321.27	2,062,605,421.30
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	794,048.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,230,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,245,800.00	15,538,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,245,800.00	15,538,380.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,324,125,748.48	4,975,582,658.55
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,337,100,035.88)	(4,879,527,610.22)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	249,386,350.42	(692,559.07)

Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

14	Бусад эх үүсвэр	249,386,350.42	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	249,386,350.42	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	692,559.07
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	692,559.07
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(763,587,936.98)	95,362,489.26
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,713,531,333.71	1,949,943,396.73
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,949,943,396.73	2,045,305,885.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		18,939,684,638.30	18,939,684,638.30
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		18,939,684,638.30	18,939,684,638.30
Тайлант үеийн үр дүн		30,243,411,310.84	30,243,411,310.84
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		49,183,095,949.14	49,183,095,949.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		49,183,095,949.14	49,183,095,949.14
Тайлант үеийн үр дүн		24,592,309,640.93	24,592,309,640.93
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		73,775,405,590.07	73,775,405,590.07

Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,746,138,000.00	28,735,191,428.57	10,946,571.43	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	2,785,138,000.00	2,775,425,374.02	9,712,625.98	99.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,785,138,000.00	2,775,425,374.02	9,712,625.98	99.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	493,299,300.00	487,555,147.05	5,744,152.95	98.9
Үндсэн цалин	493,299,300.00	487,555,147.05	5,744,152.95	98.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлсөн шимтгэл	62,130,000.00	60,915,205.88	1,214,794.12	98.0
Тэтгэврийн даатгал	42,248,400.00	41,422,340.00	826,060.00	98.0
Тэтгэмжийн даатгал	4,970,400.00	4,873,216.47	97,183.53	98.0
ҮОМШӨ-ний даатгал	3,976,300.00	3,898,573.18	77,726.82	98.0
Ажилгүйдлийн даатгал	994,100.00	974,643.29	19,456.71	98.0
Эрүүл мэндийн даатгал	9,940,800.00	9,746,432.94	194,367.06	98.0
Байрны ашиглалтын тогтмол зардал	85,890,000.00	85,874,630.00	15,370.00	99.9
Байрны түрээс	85,890,000.00	85,874,630.00	15,370.00	99.9
Хангамж, бараа материалын зардал	15,194,700.00	15,143,293.79	51,406.21	99.7
Бичиг хэрэг	6,394,700.00	6,394,693.00	7.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,900,000.00	6,866,800.79	33,199.21	99.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн зүйлс	1,900,000.00	1,881,800.00	18,200.00	99.0
Нормативд зардал	4,529,000.00	4,477,000.00	52,000.00	98.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,529,000.00	4,477,000.00	52,000.00	98.8
Эд хогшил, урсгал засварын зардал	12,066,900.00	11,843,328.00	223,572.00	98.1
Багаж, техник хэрэгсэл	10,466,500.00	10,242,928.00	223,572.00	98.1
Урсгал зардал	1,600,400.00	1,600,400.00	-	100.0
Томилолт, зочны зардал	43,234,000.00	42,547,800.00	686,200.00	98.4
Дотоод албан томилолт	43,234,000.00	42,547,800.00	686,200.00	98.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,068,337,700.00	2,066,630,169.30	1,707,530.70	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,064,312,000.00	2,062,605,421.30	1,706,578.70	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	795,000.00	794,048.00	952.00	99.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,230,700.00	3,230,700.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	456,400.00	438,800.00	17,600.00	96.1
Бараа үйлчилгээний бусад зардал	456,400.00	438,800.00	17,600.00	96.1
Хөрөнгийн зардал	25,961,000,000.00	25,959,766,054.55	1,233,945.45	100.0
Барилга байгууламж	25,102,500,000.00	25,101,444,875.55	1,233,945.45	100.0
Тоног төхөөрөмж	858,500,000.00	858,321,179.00	178,821.00	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,746,138,000.00	28,829,976,721.29	(83,838,721.29)	100.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	28,746,138,000.00	28,829,976,721.29	(83,838,721.29)	100.3
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	28,746,138,000.00	28,829,976,721.29	(83,838,721.29)	100.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,949,250,837.66		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,045,305,885.99		
Төсвийн тохируулга		1,269,755.61		
АЖИЛЛАГСДЫН ТОО	13	12	1	92.3
Удирдах ажилтан	2	2	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	11	10	1	90.9

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,605,927.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 303.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,605,624.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлсэн.

3.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
БШУЯ-ны ТНБД-н 2023 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн В/40 тушаалаар ТХН-ийн жолоочийг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн. ТХН-д жолоочийн хариуцаж байсан тээврийн хэрэгсэл, багаж хэрэгслийг хүлээлцэх явцад 303.0 мянган төгрөгийн багажийг хүлээлгэж өгөөгүй дутаасан байна.	1	303.0	1	303.0								
Тайлант хугацаанд төслийн санхүүжилтээр баригдаж буй барилга угсралтын ажил, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч нарт, барааны худалдан авалтад төлсөн 229,034.7 мянган төгрөгийн төлбөрийг нотлох цахим “төлбөрийн баримт”-аар баталгаажуулаагүй байна.	1	229,034.7			1	229,034.7						
"Эм Ай Эс Эс" ХХК нь CW-08/01/2021 дугаартай сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын гэрээг 2021.08.06-ний өдөр байгуулсан, 2022.08.01-ний өдөр барьж дуусгах гэрээний үүрэгтэй боловч 2023 оны байдлаар барилгын ажил зогсонги байдалтай, гэрээний гүйцэтгэл 90%-тай байна. Барилгын гэрээний нийт дүн 2,162,991.6 мянган төгрөг, 2023.12.31-ний байдлаар 1,732,758.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч гэрээний үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.	1	430,232.8			1	430,232.8						

Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>Бианконеро Констракшн” ХХК-тай CW-11/2022 тоот цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын гэрээг 2022.04.01-ний өдөр байгуулсан, гүйцэтгэх хугацааг гэрээний нэмэлт өөрчлөлтөөр 2023.06.30-ны өдөр барьж дуусгахаар гэрээлсэн боловч 2023 оны байдлаар барилгын ажил удаашралтай, гэрээний гүйцэтгэл 75%-тай байна. 2023.12.31-ний байдлаар гэрээний нийт дүн 4,840,092.6 мянган төгрөг (2023 онд материалын үнийн өсөлтийн гэрээгээр 886,275.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн)-с, 2,893,735.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон ба гүйцэтгэгчээс гэрээний үүргээ биелүүлээгүй байна.</p>	1	1,946,356.6			1	1,946,356.6							
<p>Нийт дүн</p>	4	2,605,927.1	1	303.0	3	2,605,624.1	-	-	-	-	-	-	-